



**НИЙСЛЭЛИЙН  
ӨМЧИЙН АШИГЛАЛТ, УДИРДЛАГЫН ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ**

2020 оны 12 сарын 22 өдөр

Дугаар 1/1591

Улаанбаатар хот

Баянзүрх дүүргийн 55 дугаар сургуулийн  
данс бүртгэлд хөрөнгө бүртгэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 75 дугаар зүйлийн 75.1 дэх хэсэг, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолоор батлагдсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын 1 дүгээр зүйлийн 1.3 дахь хэсэг, 3 дугаар зүйлийн 3.2.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Эргэлтийн бус хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс”-ын 2020 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн хурлын шийдвэрийн дагуу хавсралтад заасан нийт 18,078,425.50 /арван найман сая далан найман мянга дөрвөн зуун хорин таван төгрөг тавин мөнгө/ төгрөгийн үнэ бүхий эргэлтийн бус хөрөнгийг данс бүртгэлд бүртгэн авахыг Баянзүрх дүүргийн 55 дугаар сургууль /Ч.Ганбилэг/-д зөвшөөрсүгэй.
2. Өмчийн мэдээллийн санд хөрөнгийн хөдөлгөөний холбогдох өөрчлөлт хийж ажиллахыг Баянзүрх дүүргийн 55 дугаар сургууль /Ч.Ганбилэг/-д үүрэг болгосугай.
3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Орлогч дарга Д.Төмөрбаатарт даалгасугай.

ДАРГА  М.БАЯРАА



Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын газрын даргын 2020 оны *А* дугаар сарын *22* -ны өдрийн *А/391* дугаар тушаалын хавсралт

Эргэлтийн бус хөрөнгийн дансанд бүртгэх хөрөнгийн жагсаалт

Байгууллагын нэр: Баянзүрх дүүргийн 55 дугаар сургууль

№	Эд хөрөнгийн нэр	Марк дугаар	Үзүүлэлт	Ашиглалтад авсан он	Чанар байдал	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Бүртгэх анхны		Хандивлагч байгууллага нэр	Эх үүсвэр
								Нэгжийн үнэ	Нийт үнэ		
1	Проекторын дэлгэц	ES244	цагаан	2019	сайн	ш	1	215,900	215,900.5	ДЗОУБ	Хандив
2	Принтер	Canon MF3010	print, copy, scan	2019	сайн	ш	1	551,873	551,873.0		
3	Проектор	Epson EB-107	цагаан	2019	сайн	ш	1	1,531,260	1,531,260.0		
4	Процессор	Dell 7040	i7,8GB	2019	сайн	ш	1	1,950,000	1,950,000.0		
5	Дэлгэц	Dell 18.5 E1916H	LED,	2019	сайн	ш	1	237,405	237,405.0		
6	Цахилгаан үүсгэвэр	Gal V1	Саарал	2019	сайн	ш	1	1,248,000	1,248,000.0		
7	Аюулын дохиолол	Sigen alarm	1-2км	2019	сайн	ш	1	437,727	437,727.0		
8	Ус цэвэршүүлэгч		саарал	2019	сайн	ш	6	930,000	5,580,000.0		
9	Дифузертэй хөгжим	DIG205 MP3,4	хар	2019	сайн	ш	1	751,900	751,900.0		
<b>Тоног төхөөрөмжийн дүн</b>									<b>12,504,065.5</b>		
1	Номын тавиур	200*80*40	Модон бор	2019	сайн	ш	1	456,000	456,000.0	ДЗОУБ	Хандив
2	Сургалтын ширээ	1200*500*750	Бор шаргал	2019	сайн	ш	8	131,370	1,050,960.0		
3	Сургалтын сандал	ANU V1	Хар	2019	сайн	ш	20	44,370	887,400.0		
4	Тавцантай сандал	хятад	Хар	2019	сайн	ш	20	159,000	3,180,000.0		
<b>Тавилга, эд хогшлийн дүн</b>									<b>5,574,360.0</b>		
<b>Нийт бүртгэх хөрөнгийн дүн</b>									<b>18,078,425.5</b>		

/төгрөгөөр/

